

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2026/4/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2026 он

Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Д.Баярсайхан  
Утас:261945 Цахим хаяг: [bayarsaikhand@audit.gov.mn](mailto:bayarsaikhand@audit.gov.mn)  
Аудитын менежер: Э.Энхбаатар  
Утас: 261885 Цахим хаяг: [enkhbaatare@audit.gov.mn](mailto:enkhbaatare@audit.gov.mn)  
Ахлах аудитор: П.Батцэцэг  
Утас: 261628 Цахим хаяг: [battsetseqp@audit.gov.mn](mailto:battsetseqp@audit.gov.mn)  
Аудитор: С.Алтанхуяг  
Утас: 261628 Цахим хаяг: [altankhuyags@audit.gov.mn](mailto:altankhuyags@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал.....	11
3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	20
4.1 Ерөнхий зүйл .....	20
4.2 Материаллаг байдал.....	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	22
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	24
6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ .....	28

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БТГ	Байнгын төлөөлөгчийн газар
ГХС	Гадаад харилцааны сайд
ДТГ	Дипломат төлөөлөгчийн газар
ДБҮЭГ	Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СС	Сангийн сайд
ХШҮДАГ	Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газар
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ӨХБЗ	Өмч хамгаалах байнгын зөвлөл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЮНЕСКО МҮК	ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс
ЭСЯ	Элчин сайдын яам



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30  
Цахим шуудан: info@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД  
Б.БАТЦЭЦЭГ ТАНАА

2026. 04. 27 № 1151  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд Гадаад харилцааны сайдын төсөвт төвлөрүүлэх орлогыг 9,100.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 11,321.1 сая төгрөгөөр биелэсэн байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн “Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын талуудын 17 дугаар Бага хурал(COP17)-ын бэлтгэл ажлыг эрчимжүүлэх тухай” 36 дугаар тогтоолоор Гадаад

харилцааны яамны дэргэдэх Ажлын албыг Үндэсний хорооны дэргэд шилжүүлэн ажиллуулахаар тогтоосон боловч тус ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Гадаад харилцааны сайдын багцад нэгтгэн тайлагнаж байна.

### **Бусад асуудал**

Гадаад харилцааны яам нь тайлант онд Ерөнхийлөгчийн түвшинд 17, Улсын Их Хурлын даргын түвшинд 5, Ерөнхий сайдын түвшинд 3, Гадаад харилцааны сайдын түвшинд 18 айлчлал, Засгийн газар хоорондын комиссын 6 хуралдаан, Гадаад харилцааны яамд хоорондын 20 зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг 96.7 хувьтай хэрэгжүүлэн ажилласан талаар тус яамны Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газраас үнэлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу 2025 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4-т заасны дагуу төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан баримт бичгийг саадгүй гарган өгч, мэдээллээр бүрэн хангаж ажилласан.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С. МАГНАЙСҮРЭН

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

*/мянган төгрөгөөр/*

Код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>20,083,078.4</b>	<b>22,438,039.7</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	9,064,780.2	8,140,656.2
33	АВЛАГА	4,224,779.3	7,539,384.2
34	УРЬДЧИЛГАА	1,014,274.3	347,749.2
35	БАРАА МАТЕРИАЛ	5,779,244.6	6,410,250.1
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>515,118,640.2</b>	<b>509,988,746.1</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	515,118,640.2	509,988,746.1
39100	Газар	46,095,332.2	46,095,332.2
39200	Биет хөрөнгө	423,278,451.7	418,178,206.2
39300	Биет бус хөрөнгө	45,744,856.3	45,715,207.7
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>535,201,718.6</b>	<b>532,426,785.8</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,736,120.8</b>	<b>2,375,616.9</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,148,680.6	1,815,782.6
41300	Өглөг	3,137,164.4	1,713,553.2
41400	Урьдчилж орсон орлого	11,516.3	102,229.4
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	587,440.2	559,834.3
42200	Урт хугацаат зээл	587,440.2	559,834.3
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>531,465,597.8</b>	<b>530,051,168.9</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	531,465,597.8	530,051,168.9
51100	Засгийн газрын оруулсан капитал	208,458,183.0	208,458,183.0
51200	Хуримтлагдсан үр дүн	(96,981,906.2)	(98,203,072.9)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	265,290,034.0	264,912,222.6
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	154,699,287.1	154,883,836.3
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>535,201,718.6</b>	<b>532,426,785.8</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>227,108,681.5</b>	<b>264,252,686.7</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,053,269.4	264,252,686.7
120	Нийтлэг татварын бус орлого	17,053,269.4	21,101,388.0
121	Хөрөнгийн орлого	-	8,262,514
122	Тусламжийн орлого	-	234,888,784.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	210,055,412.1	-
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>226,055,824.7</b>	<b>266,355,738.5</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	217,231,292.9	258,177,680.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	162,346,216.0	209,784,263.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	57,586,150.2	70,902,604.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,614,926.1	3,292,340.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,524,512.4	32,667,922.7
2104	Хангамж, бараа материалын зардал	3,383,183.6	4,004,854.7
2105	Нормативт зардал	16,037.9	23,268.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,814,695.1	3,517,296.1
2107	Томилолт, зочны зардал	18,600,408.6	30,023,407.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,361,091.2	39,120,359.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,445,210.9	26,232,210
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,885,076.9	48,393,416.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,824,531.7	8,178,058.2
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>1,052,856.8</b>	<b>(2,103,051.9)</b>
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>503,490.8</b>	<b>2,149,660.9</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>599,701.9</b>	<b>781,799.1</b>
<b>VII</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН</b>	<b>(96,211.1)</b>	<b>1,367,861.8</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b>956,645.7</b>	<b>(735,190.1)</b>

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
<b>1</b>	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>517,432,573.4</b>		<b>517,432,573.4</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	60,922.9		60,922.9
<b>3</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>517,493,496.4</b>		<b>517,493,496.4</b>
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	4,298,366.5		4,298,366.5
5	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	8,807,132.3		8,807,132.3
7	Зарласан ногдол ашиг	(90,043.0)		(90,043.0)
<b>9</b>	<b>Тайлант үеийн үр дүн</b>	<b>956,645.7</b>		<b>956,645.7</b>
<b>10</b>	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>531,465,597.8</b>		<b>531,465,597.8</b>
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(459,827.8)		(459,827.8)
<b>13</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>531,005,770.1</b>		<b>531,005,770.1</b>
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(377,811.4)		(377,811.4)
17	Өмчид гарсан өөрчлөлт	184,549.2		184,549.2
18	Зарласан ногдол ашиг	(26,148.8)		(26,148.8)
19	Тайлант үеийн үр дүн	(735,190.1)		(735,190.1)
<b>20</b>	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>530,051,168.9</b>		<b>530,051,168.9</b>

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>233,839,374.8</b>	<b>258,453,336.0</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,011,783.3	258,453,336.0
120	Нийтлэг татварын бус орлого	23,011,783.3	23,304,902.7
122	Тусламжийн орлого	-	235,148,433.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	210,827,591.5	-
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>210,418,185.3</b>	<b>246,693,788.0</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	210,418,185.3	246,693,788.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	147,885,804.3	186,617,284.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	58,980,736.2	75,511,829.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,202,071.1	3,013,351.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,142,149.7	35,909,337
2104	Хангамж, бараа материалын зардал	4,397,996.8	4,310,183.2
2105	Нормативт зардал	31,998.5	29,032.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,789,834.9	5,846,953.9
2107	Томилолт, зочны зардал	18,134,838.1	29,970,024.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,479,996.6	27,645,644.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,726,182.5	4,380,927.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	62,532,381.0	60,076,503.7
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>23,421,189.5</b>	<b>11,759,548</b>
<b>IV</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>588,157.9</b>	<b>716,190.3</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>20,841,390.8</b>	<b>12,116,756.9</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,841,390.8	12,116,756.9
2200	Дотоод эх үүсвэрээр	20,841,390.8	12,116,756.9
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(20,253,233.0)</b>	<b>(11,400,566.6)</b>
14	Бусад эх үүсвэр	108,491.9	0.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	284,650.7	1,283,105.5
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>(176,158.8)</b>	<b>(1,283,105.5)</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>2,991,797.7</b>	<b>(924,124.0)</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,072,982.5	9,064,780.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,064,780.2	8,140,656.2

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>261,179,350,900.00</b>	<b>227,888,666,090.43</b>	<b>33,290,684,809.57</b>	<b>87.3</b>
Татварын бус орлого	261,179,350,900.00	227,888,666,090.43	33,290,684,809.57	87.3
Нийтлэг татварын бус орлого	3,100,000,000.00	11,321,131,534.73	(8,221,131,534.73)	365.2
Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	3,000,000,000.00	6,111,072,553.30	(3,111,072,553.30)	203.7
Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	100,000,000.00	5,210,058,981.43	(5,110,058,981.43)	5,210.1
<b>Тусламжийн орлого</b>	<b>258,079,350,900.00</b>	<b>216,567,534,555.70</b>	<b>41,511,816,344.30</b>	<b>83.9</b>
Төсвөөс санхүүжих	258,079,350,900.00	216,567,534,555.70	41,511,816,344.30	83.9
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>261,179,350,900.00</b>	<b>204,323,389,049.25</b>	<b>56,855,961,850.75</b>	<b>78.2</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>251,609,750,900.00</b>	<b>196,145,330,805.46</b>	<b>55,464,420,094.54</b>	<b>78.0</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>220,730,008,000.00</b>	<b>173,832,408,093.36</b>	<b>46,897,599,906.64</b>	<b>78.8</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>78,283,298,100.00</b>	<b>69,310,241,183.27</b>	<b>8,973,056,916.73</b>	<b>88.5</b>
Үндсэн цалин	73,190,595,800.00	64,326,612,865.96	8,863,982,934.04	87.9
Нэмэгдэл	3,685,754,200.00	3,556,792,774.27	128,961,425.73	96.5
Унаа хоолны хөнгөлөлт	807,830,400.00	861,007,826.38	(53,177,426.38)	106.6
Урамшуулал	599,117,700.00	565,827,716.66	33,289,983.34	94.4
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>3,010,457,200.00</b>	<b>2,997,476,150.29</b>	<b>12,981,049.71</b>	<b>99.6</b>
Тэтгэврийн даатгал	2,675,878,400.00	2,664,570,024.96	11,308,375.04	99.6
Тэтгэмжийн даатгал	83,681,600.00	83,360,208.85	321,391.15	99.6
ҮОМШӨ-ний даатгал	41,823,100.00	41,592,514.43	230,585.57	99.4
Ажилгүйдлийн даатгал	41,814,800.00	41,586,720.43	228,079.57	99.5
Эрүүл мэндийн даатгал	167,259,300.00	166,366,681.62	892,618.38	99.5
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>35,996,713,100.00</b>	<b>32,066,802,616.51</b>	<b>3,929,910,483.49</b>	<b>89.1</b>
Гэрэл, цахилгаан	2,583,848,800.00	1,754,400,959.29	829,447,840.71	67.9
Түлш, халаалт	2,809,711,700.00	1,966,045,529.78	843,666,170.22	70.0
Цэвэр, бохир ус	1,092,280,100.00	987,701,196.74	104,578,903.26	90.4
Байрны түрээс	29,510,872,500.00	27,358,654,930.70	2,152,217,569.30	92.7
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>5,914,363,200.00</b>	<b>4,054,555,662.81</b>	<b>1,859,807,537.19</b>	<b>68.6</b>
Бичиг хэрэг	550,978,800.00	497,279,443.05	53,699,356.95	90.3
Тээвэр, шатахуун	2,220,553,600.00	1,588,575,469.04	631,978,130.96	71.5
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,739,701,200.00	1,164,487,136.57	575,214,063.43	66.9
Ном, хэвлэл	40,000,000.00	-	40,000,000.00	-
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	196,202,700.00	138,895,413.71	57,307,286.29	70.8
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,166,926,900.00	665,318,200.44	501,608,699.56	57.0
<b>Нормативт зардал</b>	<b>60,166,700.00</b>	<b>29,073,622.34</b>	<b>31,093,077.66</b>	<b>48.3</b>
Нормын хувцас, зөөлөн эдлэл	60,166,700.00	29,073,622.34	31,093,077.66	48.3
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>13,765,123,700.00</b>	<b>8,221,577,809.54</b>	<b>5,543,545,890.46</b>	<b>59.7</b>
Багаж, техник, хэрэгсэл	8,451,349,300.00	3,535,734,849.63	4,915,614,450.37	41.8
Тавилга	373,000,000.00	131,842,000.00	241,158,000.00	35.3
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	47,679,400.00	-	47,679,400.00	-
Урсгал засвар	4,893,095,000.00	4,554,000,959.91	339,094,040.09	93.1
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>36,894,271,200.00</b>	<b>29,858,115,597.17</b>	<b>7,036,155,602.83</b>	<b>80.9</b>
Гадаад албан томилолт	16,603,703,700.00	11,223,480,006.69	5,380,223,693.31	67.6
Дотоод албан томилолт	97,266,000.00	12,640,405.00	84,625,595.00	13.0
Зочин төлөөлөгч хүлээн авах	20,193,301,500.00	18,621,995,185.48	1,571,306,314.52	92.2

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>41,595,548,100.00</b>	<b>24,664,902,439.18</b>	<b>16,930,645,660.82</b>	<b>59.3</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,283,717,200.00	8,018,163,546.56	13,265,553,653.44	37.7
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	12,687,700.00	2,057,000.00	10,630,700.00	16.2
Даатгалын үйлчилгээ	18,872,426,700.00	15,882,890,347.33	2,989,536,352.67	84.2
Тээврийн хэрэгслийн татвар	226,200.00	226,200.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	63,000.00	-	63,000.00	-
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	780,994,500.00	399,522,812.92	381,471,687.08	51.2
Газрын төлбөр	98,042,100.00	78,152,237.30	19,889,862.70	79.7
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	546,890,700.00	283,890,295.07	263,000,404.93	51.9
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	500,000.00	-	500,000.00	-
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,210,066,700.00</b>	<b>2,629,663,012.25</b>	<b>2,580,403,687.75</b>	<b>50.5</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	5,162,139,700.00	2,614,748,012.25	2,547,391,687.75	50.7
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	47,927,000.00	14,915,000.00	33,012,000.00	31.1
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>30,879,742,900.00</b>	<b>22,312,922,712.10</b>	<b>8,566,820,187.90</b>	<b>72.3</b>
<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>16,175,141,600.00</b>	<b>14,877,427,079.53</b>	<b>1,297,714,520.47</b>	<b>92.0</b>
Засгийн газрын гадаад шилжүүлэг	16,175,141,600.00	14,877,427,079.53	1,297,714,520.47	92.0
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>14,704,601,300.00</b>	<b>7,435,495,632.57</b>	<b>7,269,105,667.43</b>	<b>50.6</b>
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	602,640,000.00	548,444,505.00	54,195,495.00	91.0
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,121,952,000.00	6,286,501,126.57	5,835,450,873.43	51.9
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,880,098,000.00	560,682,001.00	1,319,415,999.00	29.8
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	99,911,300.00	39,868,000.00	60,043,300.00	39.9
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>9,569,600,000.00</b>	<b>8,178,058,243.79</b>	<b>1,391,541,756.21</b>	<b>85.5</b>
Их засвар	8,378,700,000.00	6,989,925,416.80	1,388,774,583.20	83.4
Тоног төхөөрөмж	1,190,900,000.00	1,188,132,826.99	2,767,173.01	99.8
<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>-</b>	<b>23,565,277,041.18</b>	<b>(23,565,277,041.18)</b>	<b>-</b>
<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>-</b>	<b>(23,565,277,041.18)</b>	<b>23,565,277,041.18</b>	<b>-</b>
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(23,565,277,041.18)	23,565,277,041.18	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	3,513,045,048.04	(3,513,045,048.04)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,264,247,469.02	(2,264,247,469.02)	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	55	55	-	100.0
Төсвийн байгууллага	55	55	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	728.00	740.00	(12.00)	101.6
Удирдах ажилтан	69.00	74.00	(5.00)	107.2
Гүйцэтгэх ажилтан	436.00	443.00	(7.00)	101.6
Үйлчлэх ажилтан	223.00	223.00	-	100.0

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>		<b>6,281,883,947.47</b>
Татварын бус орлого		6,281,883,947.47
Тусламжийн орлого		6,281,883,947.47
Хандив тусламж /дотоод/		6,281,883,947.47
Нэмэлт санхүүжилтийн орлого		6,281,883,947.47
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		589,691,183.47
ЗГНХ, ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		882,990,850.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		4,809,201,914.00
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>6,120,447,229.29</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>6,120,447,229.29</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>6,116,447,229.29</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		<b>1,664,314,694.00</b>
Үндсэн цалин		1,664,314,694.00
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		<b>15,875,415.00</b>
Тэтгэврийн даатгал		15,875,415.00
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		<b>982,998,628.34</b>
Гэрэл, цахилгаан		12,000,000.00
Цэвэр, бохир ус		6,000,000.00
Байрны түрээс		964,998,628.34
<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>36,000,000.00</b>
Бичиг хэрэг		12,000,000.00
Тээвэр, шатахуун		17,000,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		7,000,000.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>262,016,585.00</b>
Багаж, техник, хэрэгсэл		84,456,585.00
Урсгал засвар		177,560,000.00
<b>Томилолт, зочны зардал</b>		<b>170,374,316.00</b>
Гадаад албан томилолт		150,374,316.00
Зочин төлөөлөгч хүлээн авах		20,000,000.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>1,016,722,217.93</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		767,495,263.59
Даатгалын үйлчилгээ		246,346,954.34
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		2,880,000.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>1,968,145,373.02</b>
Бараа үйлчилгээний бусад зардал		1,670,729,051.70
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		297,416,321.32
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>4,000,000.00</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		<b>4,000,000.00</b>
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		4,000,000.00
<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>		<b>161,436,718.18</b>
<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>(161,436,718.18)</b>
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт		(161,436,718.18)

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал

Гадаад харилцааны яамны эрхэм зорилгыг “Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний хөгжилд таатай гадаад орчныг бүрдүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Гадаад харилцааны яамны үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах таатай гадаад орчныг бүрдүүлэх;
- Олон улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар Монгол Улсын хөгжлийн таатай гадаад орчныг бүрдүүлэх;
- Хүмүүнлэгийн харилцааг хөгжүүлэх, хилийн чанад дахь монгол иргэд, сургууль, цэцэрлэг, холбоо, нийгэмлэгийн үйл ажиллагаанд бодит дэмжлэг үзүүлэх;
- Монгол Улсын иргэд, хувийн хэвшлийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хилийн чанадад хамгаалах зэрэг болно.

Дээрх чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д "төсвийн ерөнхийлөн захирагч" гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг” гэж заасны дагуу Монгол Улсын ерөнхий сайдын захирамжаар томилогдсон Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг нь төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Тайлант онд Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн шууд захирагч 4, засгийн газрын тусгай сан 1, төрийн өмчит үйлдвэрийн газар 1, төсвийн төвлөрүүлэн захирагч 1, нийт 7 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэжээ.

#### 3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гадаад, дотоод орчин

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд нь үйл ажиллагаандаа

Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Дипломат албаны тухай хууль, Олон улсын гэрээний тухай хууль, Дипломат харилцааны тухай Венийн конвенц, Консулын харилцааны тухай Венийн конвенц, Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Монгол улсын 2025 оны төсвийн тухай хууль;
- Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Засгийн Газрын 2025 оны “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 07 дугаар тогтоол;
- Засгийн Газрын 2025 оны "Журам батлах тухай" 43 дугаар тогтоол /Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам/;
- Сангийн сайдын 2025 оны “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” шинэчлэн батлах тухай А/3 дугаар тушаал

Удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй гэж үзлээ.

Тайлант онд яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас төлөвлөгөөний дагуу Астана, Софи, Ханой, Бээжин, Прага, Вена, Оттава хотууд дахь дипломат төлөөлөгчийн газруудын үйл ажиллагаанд дотоод аудитыг гүйцэтгэсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 онд шинэчлэн боловсруулсан Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагаанд мөрдлөг болгож ажиллах Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,774.9 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3=2-1</b>
Мөнгөн хөрөнгө	9,064.8	8,140.7	(924.1)
Авлага	4,224.8	7,539.4	3,314.6
Урьдчилгаа	1,014.3	347.7	(666.5)
Бараа материал	5,779.2	6,410.3	631.0
Үндсэн хөрөнгө	515,118.6	509,988.7	(5,129.9)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>535,201.7</b>	<b>532,426.8</b>	<b>(2,774.9)</b>
Өр төлбөр	3,736.1	2,375.6	(1,360.5)
Засгийн газрын хувь оролцоо/Эздийн өмч/	531,465.6	530,051.2	(1,414.4)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>535,201.7</b>	<b>532,426.8</b>	<b>(2,774.9)</b>

*Эх сурвалж: Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.*

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 8,140.7 сая төгрөг болж, өмнөх оноос 924.1 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт (-)
<b>Кассад байгаа бэлэн мөнгө</b>	<b>149.1</b>	<b>405.1</b>	<b>256.0</b>
Төгрөг	4.4	1.9	(2.5)
Гадаад валют	144.7	403.1	258.5
<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>6,665.7</b>	<b>3,735.6</b>	<b>(2,930.1)</b>
<b>Төгрөг</b>	<b>2,522.1</b>	<b>1,172.0</b>	<b>(1,350.1)</b>

**Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Төрийн сангийн харилцах	201.3	4.2	(197.1)
Арилжааны банк дахь харилцах	2,320.8	1,167.7	(1,153.1)
<b>Гадаад валют</b>	<b>4,143.6</b>	<b>2,563.6</b>	<b>(1,580.0)</b>
Арилжааны банк дахь харилцах	4,143.6	2,563.6	(1,580.0)
<b>Хадгаламж</b>	<b>2,250.0</b>	<b>4,000.0</b>	<b>1,750.0</b>
<b>Дүн</b>	<b>9,064.8</b>	<b>8,140.7</b>	<b>(924.1)</b>

*Эх сурвалж: Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 924.1 сая төгрөгөөр буурсан нь ГХЯ-ны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн их засварын чанарын баталгаа 197.0 сая төгрөг болон Женев дэх БТГ-ын арилжааны банкны дансанд өмнөх онд ЗГХЭГ-аас Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтад оролцохтой холбоотой 2,505.0 сая төгрөгийг холбогдох байгууллагуудад шилжүүлсэнтэй холбоотой байна.

Мөнгөн хөрөнгө дансны нийт үлдэгдлийн 22.8 хувь буюу 1,861.1 сая төгрөг нь Монгол Улсаас гадаад оронд суугаа 50 ДТГ-ын гадаад дахь арилжааны банкны харилцах дансны үлдэгдэл, 22.9 хувь буюу 1,870.2 сая төгрөг нь ДБҮЭГ-ын Монгол дахь арилжааны банкны харилцах дансны үлдэгдэл, 49.1 хувь буюу 4,000.0 сая төгрөг нь ДБҮЭГ-ын Голомт банк дахь арилжааны банкны хадгаламжийн дансны үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт:

- Техник хяналтын дансанд хөрөнгө оруулалтын ажлын техник хяналтын 4.2 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэл байршиж байна. /ГХЯ/
- Нэмэлт санхүүжилтийн харилцах данснаас анхан шатны баримтын бүрдэл хангаагүй 43.8 сая төгрөгийн гүйлгээ хийсэн /ГХЯ/
- Тайлант онд албан хаагчдын цалин тооцоходоо томилолтоор явсан албан хаагчдад хоол, унааны мөнгийг давхардуулан тооцож 16.7 сая төгрөгийг олгосон /ГХЯ/
- Гадаад томилолтын зардлаас түүвэрлэн горим сорил хэрэгжүүлэхэд тайлант онд 159.2 сая төгрөгийн томилолтын зардал томилолтын илтгэх хуудас, томилолтын тайлангүй /ГХЯ/
- Тайлант онд нийгмийн даатгалын тайланд цалинг 34.2 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан/ДБҮЭГ/
- Гадаад албан томилолтын зардлын нормыг хэтрүүлэн 3.1 сая төгрөгөөр илүү төсөвлөж, олгосон /ДБҮЭГ, 3.1 сая төгрөг/

**3.4.2 Авлага**

Авлага дансны эцсийн үлдэгдэл 7,539.4 сая төгрөг болж, өмнөх оноос 3,314.6 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл*

*/сая төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	14.7	28.3	13.6
Татаас, санхүүжилтийн авлага	259.6	3,133.3	2,873.6
Дансны авлага /ТӨҮГ/	100.3	159.6	59.3
Татвар НДШ-ын авлага /ТӨҮГ/	61.2	0.3	(60.9)
Байгууллагаас авах авлага	3,147.6	3,555.8	408.2
Хувь хүмүүсээс авах авлага	641.4	662.1	20.7
<b>Дүн</b>	<b>4,224.8</b>	<b>7,539.4</b>	<b>3,314.6</b>

*Эх сурвалж: Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.*

Авлагын үлдэгдэл 3,314.6 сая төгрөгөөр өссөн нь ДТГ-уудын үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөнөөс давж биелсэн 3,111.1 сая төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар тусгаж тайлагнасантай холбоотой байна.

Авлага дансны үлдэгдлийн 37.6 хувь буюу 2,831.7 сая төгрөг нь ДТГ-ын авлага бөгөөд энэхүү авлагын дийлэнх хувийг ДТГ-уудын ажилчдын байрны барьцаатай холбоотой авлага эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

Олон жилийн насжилттай, тооцоо нийлээгүй 63.4 сая төгрөгийн авлага байна/ДТГ/

### 3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 347.7 сая төгрөг болж, өмнөх оноос 666.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	1,014.3	140.5	(873.8)
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	-	207.3	207.3
Цалингийн урьдчилгаа	-	-	-
Томилолтын урьдчилгаа	-	-	-
<b>Дүн</b>	<b>1,014.3</b>	<b>347.7</b>	<b>(666.5)</b>

Эх сурвалж: Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 666.5 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны 742.9 сая төгрөгийн урсгал засварын ажлыг тайлант онд бүрэн дуусгаж, гэрээг дүгнэн, хүлээн авсныг тайлант онд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэснээс голлон шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Хөрөнгө оруулалтын төсөвт тусгагдаагүй, холбогдох газрын зөвшөөрөлгүй хөрөнгө худалдан авахаар 169.6 сая төгрөгийн урьдчилгаа төлбөр төлсөн/ДТГ/

### 3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 6,410.3 сая төгрөг болж, өмнөх оноос 631.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>	<b>751.6</b>	<b>848.4</b>	<b>96.9</b>
Тусгай зориулалттай материал	751.6	848.4	96.9
<b>Дуусаагүй үйлдвэрлэл</b>	<b>0.9</b>	<b>0.6</b>	<b>(0.2)</b>
<b>Бэлэн бүтээгдэхүүн</b>	<b>19.7</b>	<b>63.6</b>	<b>43.9</b>
<b>Хангамжийн материал</b>	<b>5,007.1</b>	<b>5,497.5</b>	<b>490.5</b>
Бичиг хэргийн материал	113.4	122.8	9.4
Аж ахуйн материал	528.5	603.1	74.6
Сэлбэг хэрэгсэл	142.4	149.5	7.1
Барилгын засварын материал	10.0	7.6	(2.4)
Түлш, шатах тослох материал	58.8	76.9	18.1
Хүнсний материал	613.6	610.8	(2.8)
Бусад хангамжийн материал	3,540.4	3,926.9	386.5
<b>Дүн</b>	<b>5,779.2</b>	<b>6,410.3</b>	<b>631.0</b>

Эх сурвалж: Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Бараа материалын үлдэгдэл нэмэгдсэн нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор 7,526.2 сая төгрөгийн бараа материал төсвийн хөрөнгөөр худалдан авч, 6,778.8 төгрөгийн бараа материал зарцуулж, 162.0 сая төгрөгийн бараа акталсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Бараа материалын үлдэгдэлд 2018 онд орлогод авсан ашигладаггүй 15.3 сая төгрөгийн бараа материал байршиж байна/ГХЯ/

### 3.4.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 509,988.7 сая төгрөг болж, өмнөх оноос 5,129.9 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл*

*/сая төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Газар	46,095.3	46,095.3	-
<b>Биет хөрөнгө</b>	<b>423,278.5</b>	<b>418,178.2</b>	<b>(5,100.2)</b>
Барилга, байгууламж, орон сууц	401,386.1	397,232.0	(4,154.0)
Авто-тээврийн хэрэгсэл	12,820.2	11,225.7	(1,594.5)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	4,712.6	4,761.5	48.9
Тавилга, аж ахуйн эд хогшил	3,773.3	4,371.4	598.1
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	317.9	319.8	2.0
Бусад үндсэн хөрөнгө	185.9	168.2	(17.7)
Ном	82.5	99.6	17.1
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>45,744.9</b>	<b>45,715.2</b>	<b>(29.6)</b>
Програм хангамж	100.9	71.3	(29.6)
Бусад биет бус хөрөнгө	45,643.9	45,643.9	-
<b>Дүн</b>	<b>515,118.6</b>	<b>509,988.7</b>	<b>(5,129.9)</b>

Эх сурвалж: Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,129.9 сая төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 769, 307 дугаар тогтоолуудаар 13 Дипломат төлөөлөгчийн газрын 2,805.7 сая төгрөгийн 15 авто тээврийн хэрэгсэл, 2025 оны 768, 306 дугаар тогтоолуудаар 34 Дипломат төлөөлөгчийн газрын 2,398.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хөрөнгө акталж дансаас хассан нь голлон нөлөөлжээ.

Аудитын илрүүлэлт:

- Хөрөнгийн тооллогыг хагас жилийн тооллого болон эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед хийж баталгаажуулаагүй, жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг батлагдсан маягтын дагуу чанартай хийж гүйцэтгээгүй/ГХЯ/
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 340 дүгээр тогтоолоор 391 нэрийн 1,299.1 сая төгрөгийн хөрөнгийг ӨХБЗ-ийн хяналт дор акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах ажлыг даалгасан шийдвэр гарсан боловч акталсан тухай шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, устгалын комиссын акт үйлдээгүй, дахин ашиглах, сэлбэг хэрэгслээр ашиглах боломжтой эсэхийг судлан баримтжуулаагүй/ГХЯ/
- Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланд үндсэн хөрөнгийн шинж чанар агуулаагүй хөрөнгө бүртгэж элэгдэл байгуулсан/ГХЯ/

### 3.4.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 2,375.6 сая төгрөг болж, өмнөх оноос 1,360.5 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл*

*/сая төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Өглөг</b>	<b>15.2</b>	<b>615.9</b>	<b>600.6</b>
Ажилчидтай холбогдсон өглөг	15.2	159.8	144.6
Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	456.0	456.0
<b>Бусад өглөг</b>	<b>3,121.9</b>	<b>1,097.7</b>	<b>(2,024.2)</b>

Байгууллагад төлөх өглөг	2,986.5	1,009.8	(1,976.7)
Хувь хүмүүст төлөх өглөг	92.5	15.7	(76.8)
Татварын өглөг /ТӨҮГ/	33.0	72.2	39.2
Дансны өглөг /ТӨҮГ/	9.9	-	(9.9)
<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>11.5</b>	<b>102.2</b>	<b>90.7</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>587.4</b>	<b>559.8</b>	<b>(27.6)</b>
Хойшлогдсон өр төлбөр	587.4	559.8	(27.6)
<b>Дүн</b>	<b>3,736.1</b>	<b>2,375.6</b>	<b>(1,360.5)</b>

Эх сурвалж: Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Өглөгийн үлдэгдэл буурахад Женев хот дахь БТГ-ын дансанд ЗГХЭГ-аас Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтад оролцохтой холбоотой зардал болох 2,575.8 сая төгрөгийг өглөгөөр бүртгэснийг холбогдох байгууллагад шилжүүлэн өглөгийг барагдуулсантай холбоотой байна.

### 3.4.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 530,051.2 сая төгрөг болж, өмнөх оноос 1,414.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Засгийн газрын хувь оролцоо / сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	208,458.2	208,458.2	-
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(96,981.9)</b>	<b>(98,203.1)</b>	<b>(1,221.2)</b>
Өмнөх үеийн үр дүн	(97,938.6)	(97,467.9)	470.7
Тайлант үеийн үр дүн	956.6	(735.2)	(1,691.8)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	265,290.0	264,912.2	(377.8)
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	154,699.3	154,883.8	184.5
<b>Дүн</b>	<b>531,465.6</b>	<b>530,051.2</b>	<b>(1,414.4)</b>

Эх сурвалж: Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл буурсан нь санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлант үеийн үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү болон гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүүгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 433,350.5 сая төгрөгөөр тооцон, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж хүргүүлсэн байна.

Төсвийн төсөлд өгсөн саналаас нийт зардлыг 171,059.8 сая төгрөгөөр бууруулж, урсгал зардлыг 251,040.3 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 11,250.4 сая төгрөгөөр, нийт зардлыг 262,290.7 сая төгрөгөөр анх баталсан байна.

Төсвийн тодотголоор 1,111.3 сая төгрөгөөр бууруулж, нийт эх үүсвэрийг 261,179.4 сая төгрөгөөр, урсгал зардлыг 251,609.8 сая төгрөг, хөрөнгийн зардлыг 9,569.6 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 23 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 258,079.4 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 3,000.0 сая төгрөгийг тус тус бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 216,567.5 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 6,111.1 сая төгрөгийг тус тус бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 204,323.4 сая төгрөг буюу 78.2 хувьтай байгаа нь гадаад улс орнууд дахь дипломат үйл ажиллагаа хөтөлбөрийн төсвийг 37,980.3 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 9. Хөтөлбөр, зориулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/сая төгрөгөөр/*

Дд.	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувь/
<b>Гадаад харилцааны сайд</b>		<b>261,179.4</b>	<b>204,323.4</b>	<b>56,856.0</b>	<b>78.2</b>
<b>70301</b>	<b>Гадаад улс орнууд дахь дипломат үйл ажиллагаа</b>	<b>182,883.8</b>	<b>144,903.5</b>	<b>37,980.3</b>	<b>79.2</b>
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	162,397.6	135,013.0	27,384.6	83.1
80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	43.3	-	43.3	-
80218	Улс орноо гадаадад сурталчлах	2,588.7	2,055.0	533.6	79.4
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	4,536.6	1,428.8	3,107.7	31.5
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	1,195.7	120.1	1,075.6	10.0
81820	Сургалтын төлбөрийн буцалтгүй	12,122.0	6,286.5	5,835.5	51.9
<b>70303</b>	<b>Олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх</b>	<b>20,805.0</b>	<b>15,982.2</b>	<b>4,822.8</b>	<b>76.8</b>
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	3,685.6	2,045.6	1,640.0	55.5
80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	30.5	30.5	0.0	100.0
80509	ОУ-ын байг-ын гишүүнчлэл хураамж	12,235.0	12,185.1	49.9	99.6
81520	Олон улсын хурал, зөвлөгөөн зойлчилгээ	4,806.0	1,721.0	3,085.0	35.8
81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх үйлчилгээ	47.9	-	47.9	-
<b>70304</b>	<b>Гадаад улс оронд байгаа монгол иргэдэд туслах</b>	<b>600.0</b>	<b>545.8</b>	<b>54.2</b>	<b>91.0</b>
80820	Бусад тусламж, дэмжлэглчилгээ	600.0	545.8	54.2	91.0
<b>70305</b>	<b>Гадаад харилцааны бодлого, удирдлага</b>	<b>56,890.6</b>	<b>42,891.9</b>	<b>13,998.7</b>	<b>75.4</b>
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	28,951.5	26,544.5	2,407.0	91.7
80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил үйлчилгээ	991.3	991.3	0.0	100.0
80218	Улс орноо гадаадад сурталчлах	7,277.6	884.2	6,393.4	12.1
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	2,753.1	593.3	2,159.8	21.6
80509	ОУ-ын байг-ын гишүүнчлэл хураамж	3,940.1	2,692.3	1,247.9	68.3
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	786.9	483.1	303.8	61.4
80918	Бусад	9,569.6	8,178.1	1,391.5	85.5
81520	Олон улсын хурал, зөвлөгөөн зойлчилгээ	1,523.5	1,522.8	0.7	100.0
81549	Ахмадын сан	36.2	26.2	10.0	72.4
81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх үйлчилгээ	962.0	907.4	54.6	94.3
82905	Засгийн газар хоорондын комисс	98.7	68.7	30.0	69.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу хийх 2025-2026 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаа авч үр дүнг нэгтгэн дүгнэлээ. Үүнд:

*Байгууллагуудын орон тооны цомхотголын судалгааны үр дүнгийн талаар:*

Тус төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 4 байгууллагын орон тоо 740 байсан бөгөөд Засгийн газрын бүтэц, орон тоог 9 хувиар бууруулах чиглэлийн хүрээнд орон тоог 40-аар бууруулсан. Үүнд: удирдах 3, гүйцэтгэх албан тушаалтнаас 14, үйлчлэх 23 орон тоог тус тус бууруулж ажилласан байна.

Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын талуудын 17 дугаар Бага хурал(COP17)-ыг зохион байгуулах Үндэсний хорооны Ажлын албаны бүтэц орон тоог Үндэсний хорооны даргын 2025 оны 09 сарын 01-ний өдрийн А/03 дугаар тушаалаар 2025 онд 30, 2026 онд 40 байхаар баталсан байна.

Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын судалгааны үр дүнгийн талаар:

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд нь ажлын нэг өдрийн хоолны зардлыг 7,500.00-11,000.00 төгрөгөөр 2 байгууллага, 32,000.00 төгрөгөөр 1 байгууллага, унааны зардлыг 500.00-3,000.00 төгрөгөөр тус тус тогтоож, тайлант хугацаанд хоол, унааны зардалд 1,233.8 сая төгрөг баталж, гүйцэтгэлээр нийт 1,180.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Гадаад томилолтын, арга хэмжээний судалгааны үр дүнгийн талаар:

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний 4 байгууллага гадаад томилолтын 1138 арга хэмжээнд зориулж 16,113.8 сая төгрөг төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 765 арга хэмжээнд 10,961.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Гадаад зочин, төлөөлөгч хүлээн авах 313 арга хэмжээнд зориулж 19,981.3 сая төгрөг төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 250 арга хэмжээнд 18,622.0 сая төгрөг зарцуулсан байна.

Сургалт семинар хурал зөвлөгөөний судалгааны үр дүнгийн талаар:

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний 2 байгууллага тайлант онд 6 хурал зөвлөгөөнд зориулж 1,529.3 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 1,528.2 сая төгрөгийг зарцуулсан.

Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн судалгааны үр дүнгийн талаар:

Гадаад сайдын эрхлэх асуудлын хүрээний 1 байгууллага 55 хэвлэл мэдээллийн байгууллагуудтай нийт 947.1 сая төгрөгийн ажил, үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан байна.

### **3.5.3 Худалдан авах ажиллагаа**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын 2025 оны бараа, ажил үйлчилгээний худалдан авах төлөвлөгөөнд 13,635.1 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий их засварын ажил, тоног төхөөрөмж, бараа, ажил, үйлчилгээг баталсан байна. Үүнд их засварын 5 төсөл арга хэмжээнд 8,378.7 сая төгрөг, тоног төхөөрөмжийн 4 төсөл арга хэмжээ 1,190.9 сая төгрөг, бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад 4,065.5 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 461.9 сая төгрөгийн 25 бараа, ажил, үйлчилгээг шууд худалдан авалтаар, 148.9 сая төгрөгийн ажил, үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулалтаар, ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 3.3, 3.3.5 дахь заалтын дагуу 6,989.9 сая төгрөгийн их засварын ажил хийж, 1,188.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан байна.

Аудитын илрүүлэлт:

Гадаад харилцааны яамны 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 884.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий бараа, ажил үйлчилгээг шууд гэрээ байгуулан худалдан авсан, мөн нэг төрлийн бараа, ажил үйлчилгээний төсөвт өртгийг хувааж шууд гэрээ байгуулах аргаар худалдан авахаар төлөвлөсөн/ГХЯ/

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 18.3 сая төгрөгийн худалдан авалт хийсэн /ДБҮЭГ/

### **3.5.4 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт**

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн хавсралтаар баталсан Гадаад харилцааны сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд 4 хөтөлбөрийн 9 арга хэмжээний зорилтот түвшнийг тусгасныг ХШҮДАГ-аас 96.7 хувиар үнэлсэн байна.

Хүснэгт 10. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн зорилт, хөтөлбөрийн хүрэх үр		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Үнэлгээ /хувь/	
<b>70305 Гадаад харилцааны бодлого, удирдлага</b>					
23.1	<b>23.1.1. Монгол Улсын гадаад бодлогыг хэрэгжүүлэх, гадаад улс төр, худалдаа, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.</b>				
	23.1.1.1	Гадаад харилцааны бодлого, удирдлагын чиглэлээр зохион байгуулах сургалт семинар	5	13	100
	23.1.1.2	Засгийн газар хооронд байгуулах хэлэлцээр	30	27	90
	23.1.1.3	Зөвлөлдөх уулзалт, дугуй ширээний уулзалт	15	20	100
	23.1.1.4	Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээг хэвлэн нийтлэх	400	313	78
	<b>23.1.2. Хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж, айлчлал, арга хэмжээний давтамжийг нэмэгдүүлнэ.</b>				
23.1.2.1	Өндөр, дээд түвшинд зохион байгуулах айлчлал арга хэмжээний тоо	10	43	100	
<b>70301 Гадаад улс дахь дипломат үйл ажиллагаа</b>					
23.2	<b>23.2.1 Гадаад улс дахь дипломат үйл ажиллагаа</b>				
	23.2.1.1	Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгжийн хууль ёсны эрх ашгийг тууштай хамгаалж, эрх зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна..	165200	163000	90
	23.2.2.1	Монгол Улсын иргэдийг визийн шаардлагаас чөлөөлөх хэлэлцээрийг гадаад улсуудтай үргэлжлүүлэн байгуулна.	75	76	100
<b>70304 Гадаад улс оронд байгаа Монгол иргэдэд туслах</b>					
23.3	<b>23.3.1 Гадаад улс оронд байгаа монгол иргэдэд туслах сан</b>				
	23.3.1.1	Гадаад улсад байгаа Монгол Улсын иргэдийн гаргасан хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэнэ.	97.8	100	100
<b>70303 Олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх</b>					
23.4	<b>23.4.1 ЮНЕСКО-д бүртгүүлэх биет болон биет бус өвийг бүртгүүлнэ.</b>				
	23.4.1.1	ЮНЕСКО-д бүртгүүлэх биет болон биет бус өв	1	5	100.0

### 3.5.5 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийн 589.7 сая төгрөг, Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 882.9 сая төгрөг, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 4,809.2 сая төгрөг, нийт 6,281.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр, урсгал зардалд 6,116.4 сая төгрөгийг зарцуулж, 161.4 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд тус төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудлын орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын төсвийн төлөвлөлт, орлого төлөвлөлт, дотоод хяналтыг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор П.Батцэцэг, аудитор С.Алтанхуяг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Э.Энхбаатар, Тусгай чиг үүргийн газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 01/1506 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 226,055.8 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 2,260.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тайлант оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал өмнөх оноос 41,010.5 сая төгрөгөөр өссөн материаллаг өөрчлөлттэй байгаа тул материаллаг байдлын түвшнийг шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзлээ.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага болон дээд шатны төсвийн захирагчаас төрийн хэмнэлттэй холбоотой тушаал, шийдвэр гарах, арга хэмжээ авах нөхцөл байдал үүсээгүй, 2025 оны баталсан төсөвт багтаан үйл ажиллагаагаа явуулсан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийцлийн асуудлаар нийт 3,074.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 3,056.0 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, 18.4 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж хүргүүлсэн байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллага болох Хилийн чанд дахь иргэдэд туслах сан нь шилэн дансны нэгдсэн цахим системд бүртгэгдээгүйтэй холбоотойгоор тус сангийн төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналтай холбоотой мөнгөн болон бусад мэдээлэл байршаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3.2-т Энэ хуульд дараах төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал эдгээртэй холбоотой мөнгөн болон бусад гүйлгээ хамаарна: 3.2.3-т Засгийн газрын тусгай сан; 3.4-т Төрийн нууцад хамаарахаас бусад төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналыг байгууллагын нууцад хамааруулан нийтэд мэдээлэхээс зайлсхийхийг хориглоно; 4.1.3-т тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналт шалгалтыг сайжруулах зөвлөмж өгөв.

Аудитын илрүүлэлт:

- Шилэн дансны цахим хуудаст мэдээлэх цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын нийт мэдээлэх 309 мэдээллээс орлогын 1,843.0 сая төгрөгийн 5 мэдээлэл, зарлагын 3,515.4 сая төгрөгийн 36 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан/ГХЯ/

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

##### Албан шаардлага

1. Цөлжилтэй тэмцэх тухай НҮБ-ын конвенцын талуудын 17 дугаар бага хурлыг зохион байгуулах үндэсний хорооны ажлын алба нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлуулаагүй, эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй дараах бараа, ажил, үйлчилгээг шууд гэрээ байгуулан худалдан авсан байна. Үүнд:
  - Тайлант онд тендер сонгон шалгаруулалтгүй хэвлэл, мэдээллийн 55 байгууллагатай нийт 947.1 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээг шууд худалдан авалтын үнийн дүнд багтаан жижиглэж шууд гэрээ байгуулсан;
  - Ажлын албаны урсгал зардлаас тендер сонгон шалгаруулалтгүй 141.8 сая төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж, 149.5 сая төгрөгийн тавилга, эд хогшил, нийт 291.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шууд худалдан авсан;
  - Эрх бүхий байгууллагын тушаал шийдвэргүйгээр ажлын албаны урсгал зардлаас сургалт, судалгааны зардал 190.5 сая төгрөг, хурлын байр байгууламжийн ТЭЗҮ боловсруулах судалгааны ажлын зардалд 134.7 сая төгрөг, нийт 325.2 сая төгрөгийг Нийслэлийн тамгын газрын харьяа КОП-17 Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын газарт шилжүүлсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйл "Худалдан авах ажиллагааг төлөвлөх" 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална"; 44.2-т "Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, үйлчилгээг тусгасан байна"; Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "Санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйл "Төсвийн зарлага"-ийн 24.4-д "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "үр ашигтай байх", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална."; 10 дугаар зүйлийн 10.3-д "Захиалагч шууд

худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно"; Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 1 сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор батлагдсан "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" тогтоолын 02 дугаар хавсралт "Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн:** Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлуулаагүй, эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй бараа, ажил, үйлчилгээг худалдан авсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

2. Ажлын албаны дарга болон албан хаагчдын үндсэн цалинг тогтоохдоо жишиг, судалгаа тооцоонд үндэслэлгүйгээр тогтоосон байна. Үүнд:

- Цөлжилтэй тэмцэх тухай НҮБ-ын конвенцын талуудын 17 дугаар бага хурлыг зохион байгуулах үндэсний хорооны даргын 2025 оны 8 сарын 22-ны өдрийн Б/01 дугаар тушаалаар Ажлын албаны даргын үндсэн цалинг 10.0 сая төгрөгөөр;
- Цөлжилтэй тэмцэх тухай НҮБ-ын конвенцын талуудын 17 дугаар бага хурлыг зохион байгуулах үндэсний хорооны ажлын албаны даргын 2025 оны 9 сарын 1-ний өдрийн А/03 дугаар тушаалаар Ажлын албаны албан тушаалын үндсэн цалинг 2.8-6.0 сая төгрөгөөр тус тус тогтоосон байна.

Энэ нь Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 238 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Монгол Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг зарим байгууллагын ажлын алба болон адилтгах бусад байгууллага, зөвлөлийн ажлын албаны албан тушаалын цалингийн хэмжээ" гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн:** Албан хаагчдын үндсэн цалинг тогтоохдоо жишиг, судалгаа тооцоонд үндэслэн тогтоогүй зөрчлийг таслан арилгах албан шаардлага хүргүүлэв.

**Аудитын илрүүлэлт:**

Тушаалын үндэслэл буруу тусгасан, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлаагүй, худалдан авах ажиллагааг мэргэжлийн бус албан хаагчаар гүйцэтгүүлсэн/ГХЯ/ Орлогын төлөвлөгөөг 535.4 сая төгрөгөөр биелүүлээгүй/ДБҮЭГ/

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний 1 байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, бараа материал, үндсэн хөрөнгө, мөнгөн хөрөнгийн данстын хувьд горим, сорил хэрэгжүүлж, аудитаар илэрсэн алдаа зөрчлийг жилийн эцсийн байдлаар нэгтгэн дүгнэж, төсвийн шууд захирагчийн аудитын тайланд тусгасан болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн:

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид зөрчил арилгах 1 албан шаардлага, 2 зөвлөмж тус тус хүргүүлснээс хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 11. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Илрүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	-	1	-	65.0
Зөвлөмж	2	-	1	-	75.0
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>70.0</b>

Өмнөх оны аудитаар өгсөн 1 зөвлөмжийг хэрэгжүүлсэн, 1 албан шаардлага 1 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Өмнөх аудитаар өгсөн Төсвийн ерөнхийлөн захирагчийн Төсвийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүн, жилийн төсвийн хязгаартай уялдуулж үндэслэлтэй боловсруулж байх, санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн харьяа байгууллагуудын санхүүгийн аудитаар 2,540.4 сая төгрөг, нийцлийн аудитаар 3,074.3 сая төгрөг, нийт 5,614.7 сая төгрөгийн залруулаагүй алдаа, зөрчил илэрсэн нь өмнөх оны нийт зөрчлөөс 381.6 сая төгрөгөөр өссөн нь зөрчлийн дүнг бууруулж ажиллах талаарх зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй тул албан шаардлага хүргүүллээ.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Урсгал төсвөөс хөрөнгө бэлтгэж байгаа асуудал, Улсын төсөвт төвлөрүүлэх тэмдэгтийг хураамжийн төлбөрийг төлөвлөж Төсвийн тухай хуульд батлуулж байгаа асуудлуудыг тус тус дараагийн аудитаар анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,661.7 сая төгрөгийн 5 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 316.3 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 1,345.4 сая төгрөгийн 2 алдааг залруулах зөвлөмж өглөө.

Аудитаар нийт 1,195.1 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 24.1 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 468.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах 12 албан шаардлага хүргүүлж, 702.5 сая төгрөгийн зөрчилд 20 зөвлөмж өгсөн.

Нийт 2,540.4 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 130.3 сая төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

### 5.1 Харьяа байгууллагууд

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 7 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс “Өөрчлөлтгүй” 3, “Хязгаарлалттай” 1 санал дүгнэлт өгч, 3 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,661.7 сая төгрөгийн 5 алдаа илэрснээс аудитын явцад 316.3 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 1,345.4 сая төгрөгийн 2 алдааг залруулах зөвлөмж өгч, нийт 1,195.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 24.1 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 468.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах 11 албан шаардлага хүргүүлж, 702.5 сая төгрөгийн зөрчилд 18 зөвлөмж өгсөн.

#### 5.1.1 Төлбөрийн акт

*Илрүүлэлт 1:* Цөлжилттэй тэмцэх НҮБ-ын конвенцын талуудын 17 дугаар бага хурал (COP-17)-ын бэлтгэл ажлын алба нь тайлант онд гадаад томилолтоор ажиллаагүй албан хаагчаас томилолтын зардал 3.2 сая төгрөгийг суутган авч төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 45 дугаар зүйлийн 45.2-т “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.2-т “Төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Томилолтоор ажиллаагүй албан хаагчаас олгосон томилолтын зардлыг суутган авч төсөвт төвлөрүүлэх.

#### 5.1.2 Албан шаардлага

*Илрүүлэлт 1:* Цөлжилттэй тэмцэх НҮБ-ын конвенцын талуудын 17 дугаар бага хурал (COP-17)-ын бэлтгэл ажлын албаны тайлант оны гадаад томилолтын зардлаас түүвэрлэн горим сорил хэрэгжүүлэхэд 198.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

1. Судалгаа болон харьцуулалтгүйгээр Бүгд найрамдах Турк улсад ажиллах 2 албан хаагч, Панамад ажиллах 2 албан хаагчийн тийзийн төлбөрт 49.0 сая төгрөгийг Эйр транс ХХК-д шилжүүлсэн;

2. Гадаад томилолтоор Кени, Панама улсад ажилласан 16 ажилтны тийзийн төлбөрт нийт 149.2 сая төгрөгийг судалгаа болон харьцуулалтгүй “Аялал, жуулчлалын агентлаг, аяллын оператор болон захиалгат бусад үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлдэг” Тапа Трип Эжэнси ХХК-д шилжүүлсэн байна.

<sup>1</sup> Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Судалгаа болон харьцуулалтгүй шууд гэрээ байгуулж, тийзийн төлбөрийг өндөр үнээр тооцож, шилжүүлсэн зэрэг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгөв.

### 5.1.3 Зөвлөмж

#### 1. Хөрөнгө оруулалтын данстай холбоотой асуудал

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 6,989.9 сая төгрөгийн их засварын ажил, 1,188.1 сая төгрөгийн тоног төхөөмж худалдан авах ЭШХО-ын гүйцэтгэл, мэдээ тайланг улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем/publicinvestment.gov.mn/-д оруулж тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т "Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг үйл ажиллагааг улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд хэрэгжүүлнэ"; Засгийн газрын 2023 оны 278-р тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 1.6. Энэ журмын 1.5-д зааснаас бусад төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих, тайлагнах, мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг үйл ажиллагааг Төсвийн тухай хуулийн 29.4-т заасны дагуу Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (цаашид "цахим систем" гэх)-ээр хэрэгжүүлнэ; Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалын 3.4-т "Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг эрх шилжүүлсэн төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахим системээр тайлагнана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, ЭШХО-ын гүйцэтгэл, мэдээ тайланг улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем/publicinvestment.gov.mn/-д оруулж тайлагнаж байх.

#### 2. Хилийн чанд дахь иргэдэд туслах сангийн зарцуулалтай холбоотой асуудал

Хилийн чанадад байгаа Монгол улсын иргэдэд туслах сангийн зөвлөлийн 2025 оны 6,7 дугаар хурлын шийдвэрийг үндэслэн 3 ДТГ-уудад олгох 31.7 сая төгрөгийг Гадаад харилцааны яамны долларын дансанд шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн зөвлөлийн шийдвэртэй мөнгөн хөрөнгийг бусад данс руу гүйлгэн шилжүүлж зарцуулахгүй байх.

### 5.2 Төсвийн ерөнхийлөн захирагч

Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар 3 зөрчил илэрснээс 2 зөрчилд зөвлөмж өгч, 1 зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлээ.

#### 5.2.1 Албан шаардлага

1. Өмнөх аудитаар өгсөн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүн, жилийн төсвийн хязгаартай уялдуулж үндэслэлтэй боловсруулж байх, санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэсэн харьяа байгууллагуудын санхүүгийн аудитаар илэрсэн нийт алдаа, зөрчлийн бууруулах талаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, нийт алдаа, зөрчил өмнөх оноос 5.7 хувиар өсөж 5,614.7 сая төгрөг болсон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох", 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.10-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх"; 14.3-д "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

### **5.2.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт 1: Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 4.6.4-т заасан Гадаад харилцааны сайдын хариуцах 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг "Улсын төсөв"-ийн эх үүсвэрээр буюу 9,570.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр тусган батлуулсан боловч Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд бүрэн тусгаж батлуулаагүй, хүрэх үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшин зэргийг тодорхойлоогүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 27.1-т "Төсвийн төслийг боловсруулахад Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлагаас гадна дараах шаардлага тавигдана: 27.1.8-д "Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх"; Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.10.3-т "улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Төсвийг батлуулахдаа төлөвлөсөн төсөл хөтөлбөр, арга хэмжээний хүрэх үр дүнг үнэлэх боломжтой байдлаар тодорхойлж батлуулах, 2027 оны төсвийн төсвийг боловсруулахдаа Улсын жилийн төлөвлөгөөнд тусгасан төсөл арга хэмжээг тусган батлуулдаг байх.

#### **Орлого төлөвлөлттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт 2: Төсвийн тухай хуулиар Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 9,100.0 сая төгрөгөөр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 11,321.1 сая төгрөгөөр биелсэн байгаа нь орлогыг бодитой төлөвлөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.5-т "төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого"; Сангийн сайдын 2025 оны 240 дугаар тушаал 3.3-д "Энэ журмын 3.1.1-т заасан орлогын сүүлийн гурван жилийн гүйцэтгэл болон 3.1.2-т заасан орлогын үндсэн үйл ажиллагаанд хамаарч үргэлжлэх байдлыг тус тус харгалзан үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Төсөвт төвлөрүүлэх орлогыг төлөвлөхдөө орлогын сүүлийн гурван жилийн гүйцэтгэл болон орлогын үндсэн үйл ажиллагаанд хамаарч үргэлжлэх байдлыг тус тус харгалзан бодитой төлөвлөж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэрс	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	Залруулсан		Залруулаагүй		тоо	дүн
								тоо	дүн	тоо	дүн		
1	Дипломат төлөөлөгчийн газар	1	145.5		-	1	145.5	1	145.5		-		
2	Гадаад харилцааны яам	1	1,308.7		-	1	1,308.7		-	1	1,308.7	1	1,308.7
3	Бусад ТШЗ	1	36.6	1	36.6		-		-	1	36.6	1	36.6
4	ЮНЕСКО-гийн МҮК дүн	2	170.8		-	2	170.8	2	170.8		-		-
	<b>Нийт</b>	<b>5</b>	<b>1,661.7</b>	<b>1</b>	<b>36.6</b>	<b>4</b>	<b>1,625.0</b>	<b>3</b>	<b>316.3</b>	<b>2</b>	<b>1,345.4</b>	<b>2</b>	<b>1,345.4</b>

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэрс	Нийт зөрчил		Үүнээс										
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага			Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	Албан тушаалтны тоо	тоо	дүн
1	Гадаад харилцааны сайд	3	-			1	-	2	-					
2	Дипломат төлөөлөгчийн газар ТТЗ	7	480.3	-	-	3.00	233.0	4.00	247.4					
3	Гадаад харилцааны яам	16	442.4	2	20.9	5	-	9	421.5					
4	Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ	3	39.3	-	-	2	37.3	1	2.0					
5	ГХС-ын Хөрөнгө оруулалт	1	-		-		-	1	-					
6	Хилийн чанд дахь иргэдэд туслах сан	1	31.7	-	-	-	-	1.00	31.7					
7	Цөлжилтэй тэмцэх тухай НҮБ-ын конвенцын талуудын 17 дугаар	2	201.3	1	3.2	1	198.1	-	-					

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	бага хурлыг зохион байгуулах үндэсний хорооны ажлын алба													
8	Бусад ТШЗ	2	-					2	-					
<b>Нийт дүн</b>		<b>35</b>	<b>1,195.1</b>	<b>3</b>	<b>24.1</b>	<b>12</b>	<b>468.5</b>	<b>20</b>	<b>702.5</b>					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэрс	Нийт зөрчил		Үүнээс										
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага			Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	Албан тушаалтны тоо	тоо	дүн
1	Гадаад харилцааны яам	4	884.9	-	-	1	884.9	3	-	-	-	-	-	-
2	Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ	3	625.7	-	-	2	607.3	1	18.4	-	-	-	-	-
3	Хилийн чанд дахь иргэдэд туслах сан	1	-					1	-	-	-	-	-	-
4	Цөлжилтэй тэмцэх тухай НҮБ-ын конвенцын талуудын 17 дугаар бага хурлыг зохион байгуулах үндэсний хорооны ажлын алба	2	1,563.7			2	1,563.7			-	-	-	-	-
<b>Нийт дүн</b>		<b>10</b>	<b>3,074.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>5</b>	<b>3,056.0</b>	<b>5</b>	<b>18.4</b>				<b>-</b>	<b>-</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1385/А0111371

Улаанбаатар хот

САГ-2026/4/НА-СТА-ТЕЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар өгсөн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүн, жилийн төсвийн хязгаартай уялдуулж үндэслэлтэй боловсруулж байх, санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэсэн харьяа байгууллагуудын санхүүгийн аудитаар илэрсэн нийт алдаа, зөрчлийн бууруулах талаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, нийт алдаа, зөрчил өмнөх оноос 5.7 хувиар өсөж нийт 5,614.7 сая төгрөг болсон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох", 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гадаад харилцааны сайд (Б.Батцэцэг) Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга (Л.Мөнхтүшиг), Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Отгонцэцэг) нарт даалгав.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

  
С.МАГНАЙСУРЭН